

“Дэлхийн Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Үндэстний хэмжээнд Тодорхойлсон Хувь нэмрийн Түншлэл/NDC partnership”-т Монгол улс гишүүнээр элслээ.



NDC-ийн Түншлэл нь өргөн цар хүрээний уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн зорилтуудыг аль болох түргэн, үр дунтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн мэдлэг, санхүүгийн дэмжлэгийн хүртэхийн тулд улс орнуудын хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилготой юм. Дотоодын байгууллагуудын оролцоотойгоор NDC-ийн Түншлэл нь салбар, бус нутаг, олон улсын байгууллага зэрэг талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж ба хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд яам, бусад оролцогч талуудтай шууд харьцааг.

Түншлэлийн гишүүд нь үйл ажиллагааны үнэлгээ, хэрэгжилтийн мониторинг, эх үүсвэрүүдийг ашиглахын тулд NDC-ийн хэрэгжилт, стратегийн боловсруулалт, дэмжих бодлогоороо дамжуулан зорилтот ба зохицуулалттай техникийн тусалцаагаар ханган ажиллага. NDC-ийн түншлэл нь дэлхийн мэдлэгийн бүтээгдэхүүний хөгжүүлэлт, өнөөгийн байгаа судалгааны дутууг гүйцэх мөн улс орнуудын туршлагаас суралцах бүтцийг бий болгох замаар мэдлэг, туршлагаа хуваалцах арга хэмжээг нэмэгдүүлнэ.

2017 онд Монгол Улс анхны NDC Түншлэлийн Форумаа зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд форумын үеэр Монголын өнөөгийн Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтын орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн эхний үе шатны (2011-2016) үнэлгээ, NDC-ийг хэрэгжүүлэх, дэмжихэд зориулсан гол стратеги, механизмыг багтаасан NDC-ийн хэрэгжилтийн замын зургийн талаар хэлэлцэх юм.

(Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ndcpartnership.org)



Холбоо барих:
Сүхбаатар дүүрэг, Амарын
гудамж, 22-р байр, 7 давхар,
Улаанбаатар хот,
Монгол Улс 14200

И-мэйл:
otgol15@gmail.com,
aminzulsh@gmail.com

Вэбхуудас:
www.jcm-mongolia.com

Англи хэлээс Монгол хэл рүү хөрвүүлсэн Ш.Аминзул, Э.Санаа



IGES
Institute for Global
Environmental Strategies

ХАМТАРСАН КРЕДИТ ОЛГОХ МЕХАНИЗМ

МЭДЭЭЛЭЛ-2017

Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ)-ын хүрээнд хоёр төсөл шинээр бүртгэгдлээ.

2017 оны 5 сард “Дархан хот дахь 10МВт-ийн нарын цахилгаан станц” болон “Улаанбаатар хотын захын эрчим хүчний хангамжид зориулсан 2.1МВт-ийн нарын эх үүсвэрт цахилгаан станцыг сууринуулах нь” нэртэй төслүүд ХКОМ-ын Монгол Японы Хамтарсан Хороонд бүртгэгдлээ.

Энэхүү 2 төсөл нь ХКОМ-ын загвар төслийн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдан Японы Байгаль Орчны Яамны дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Ийнхүү одоогийн байдлаар Монгол улсад бүртгэгдээд байсан өндөр үр ашигтай нам даралтын зуухыг сууринуулах хоёр төсөл дээр нарны эрчим хүчийг ашиглах хоёр төсөл шинээр бүртгүүлэхээр зэхж байна.



Дархан хот дахь 10МВт-ийн нарын цахилгаан станц

Дархан хотын малтмал түлш ашиглан цахилгаан үйлдвэрлэдэг байсан шугам сүлжээнд 10МВт-ийн нарын цахилгаан станцыг сууринуулсандаа 11,221 тонн CO2 эквиваленттai тэнцэх хүлэмжийн хийг жил бүр бууруулна гэж үзэж байна. Энэ нь өнөөдрийг хүртэл Монгол улсад бүртгэгдсэн төслүүдээс ХКОМ-ын хамгийн том төсөл юм. Уг төслийн хүрээнд 20,000 өрхийг цэвэр эрчим хүчээр хангах боломжтой төдийгүй ОХУ-аас импортолдог эрчим хүчийг төдий хэмжээгээр бууруулж буй юм.

Дараагийн бүртгэгдсэн төсөл болох Улаанбаатар хотын захын Моннарангийн 2.1МВт-ийн цахилгаан шугамтай холбогдсон нарын цахилгаан станц жилд ойролцоогоор 1,677тонн CO2 эквиваленттai тэнцэх хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах тооцоотой байна.

Дээрх хоёр төслийн оролцогчид Япон, Монголын ХКОМ-ын Хамтарсан Хороогоор батлагдсан Хэмжих Тайлагнах Нотлох аргазүйн дагуу төслийн үр дунд бий болох хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжилтийг хийх бөгөөд цаашид ХКОМ-ын кредит буюу хүлэмжийн хийн ялгарлын бууралтын кредитээ бүртгүүлж баталгаажуулах юм.

2017 оны 9 дүгээр сарын байдлаар Хамтарсан Хороо нь эрчим хүчний хэмнэлттэй дамжуулах шугамыг сууринуулах, өндөр үр бүтээмжтэй нам даралтын зуух болон нарны дулааны эрчим хүчний системд тохиор 3 аргазүй батлаад байна. Олон улсад ХКОМ-ын хүрээнд батлагдсан аргазүй 40 (эрчим хүчний үр ашигийг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүч, биомасс, тээвэр, хаягдал хий/дулаан ашиглалтын талаар), бүртгэгдсэн төсөл 20 байна. ХКОМ нь Япон болон бусад түншлэгч 17 улсын хооронд байгуулсан хоёр талт түншлэлийн дагуу хэрэгждэг механизмуудаа төслийн хамгийн хүчээр хангах боломжтой төдийгүй ОХУ-аас импортолдог эрчим хүчийг төдий хэмжээгээр бууруулж буй юм.

ХКОМ-ын 2 төслөөс Монгол болон Япон талд кредит олгосон нь

Төслүүдийн хэмжилтийн нэг жилийн дараа Монгол болон Японы засгийн газар “Төв аймгийн Борнуур суманд өндөр үр ашигтай нам даралтын зуухын төвлөрсөн системийг сууринуулах, шинэчлэх төсөл” болон “Улаанбаатар хотын 118-р сургуульд өндөр үр ашигтай нам даралтын зуухыг сууринуулах төсөл” 2 төслөөс 2016 оны 9 сард хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан ХКОМ-ын кредитээ олгосон. Төслийн оролцогч нарны хүснэгтээр ХКОМ-ын бүртгэлийн системд Японы талд 125 кредит олгож, Монголын талд 32 кредит тус тус олгов.

Төслийн нэгж байгууллагууд өөрсдийн төслөөс кредит авахыг хүсвэл, Япон болон Монголын бүртгэлийн системд данс нээлгэх шаардлагатай. Японы бүртгэлд олгогдсон кредит нь Японы хүлэмжийн хийн бууралтанд зүй ёсоор тооцогдоно.

(Дэлгэрэнгүй мэдээллийг: www.jcm.go.jp/mn-jp, www.jcm-mongolia.com)

Гол үйл явдал

- Монгол болон Японы засгийн газар ХКОМ-ын хүрээнд нарын цахилгаан станцийн хоёр шинэ төсөл бүртгэв.
- Монголын жижиг дунд аж ахуй нэгжүүдийн хэрэгжүүлж буй төслийг дэмжих зорилгоор Уур Амьсгалын Ногоон Сангаас(GCF) 20 сая америк доллар зээлэхээр батлагдав.
- Монгол улсын 8 дугаар сард НҮБУАӨСК-ийн Нарийн бичгийн дарга нарын газарт Конвенцийн 2 жил тутмын Үндэсний анхдуугаар тайлан-илтгэлийг өргөн барьсан. Тус тайлан-илтгэлд Үндэсний хүлэмжийн хийн тооллогын 1990-2014 онуудын тооцоо болон дэлгэрэнгүй тайлан хавсралтаар багтсан болно.
- “Дэлхийн Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр (NDC)” баримт бичгийг 2018 онд боловсруулахаар ажиллаж байна.
- Тогтвортой хөгжлийг хангахын зэрэгцээ дэмжлэгийг эргэлтэнд оруулж уур амьсгалын томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж буй улс орон, байгууллагуудын нэгдэл болох “Дэлхийн Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Үндэстний хэмжээнд Тодорхойлсон Хувь нэмрийн Түншлэл/NDC partnership”-д Монгол улсын гишүүнээр нэгдэн орлоо.

Монголын жижиг дунд аж ахуй нэгжүүдийн хэрэгжүүлж буй төслийг дэмжих зорилгоор Уур Амьсгалын Ногоон Сангас 20 сая америк доллар зээлэхээр батлагдав.



Уур Амьсгалын Ногоон Сан (GCF) нь GCF-ийн магадлан итгэмжлэгдсэн аж ахуйн нэгх болох ХасБанктай хамтран Монгол Улсад "Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөр"-т зориулан 20 сая америк долларын санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр зарлав. Энэхүү санхүүгийн дэмжлэг нь эрчим хүчиний үр ашгийг нэмэгдүүлэх болон сэргээгдэх эрчим хүчиний төслүүдэд хөрөнгө оруулалт хийж буй Монголын аж ахуйн нэгжүүдийг дэмжихэд нь ХасБанкны боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгднээ. GCF -ийн тусламжийг (97.5%-ийн зээл, 2.5%-ийн буцалтгүй тусламж) нүүрстөрөгч багатай төслүүдийг дэмждэг бусад санхүүгийн эх үүсвэрүүдтэй хослуулсанар Монголын аж ахуйн нэгжүүдийг тогтвортой, нүүрстөрөгч багатай бизнесийн загварыг нэвтрүүлэхэд нь болон одоогоор давамгайлж буй өртөг өндөртэй санхүүжилт, харьцангуй богино хугацаатай зээлийн дарамтыг даван туулахад нь туслах юм. Мөн GCF -ийн жендерийн зарчмын дагуу, санхүүгийн дэмжлэгийн хамгийн баагдаа тал хувь нь эмэгтэй захиралтай бичил, жижиг, дунд бизнест олгогдох юм.

НҮБУАӨСК-ийн Талуудын хэлэлцээрийн үр дунд GCF нь бий болсон ба хөгжик буй улс орнуудын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах эсвэл хязгаарлах замаар уур

амьсгалын өөрчлөлтийг сааруулахаар авч хэрэгжүүлж буй хүчин чармайлтыг нь дэмжих зорилготой юм. Дэмжлэгийг уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах аргахэмжээнд зориулан эн тэнцүү хэмжээгээр буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл, өөрийн хөрөнгөнд хөрөнгө оруулах, зээлийн баталгаа гаргах хэлбэрээр үзүүлнэ. GCF нь дэмжлэгээ төслийн санал боловсруулалт, төсөл хөтөлбөрийн менежментийн төлөвлөгөөгээ багтаасан бичиг баримтаяа өргөн барьсан, үйл ажиллагаа нь батламжлагдсан Магадлан Итгэмжлэгдсэн Байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлэх юм.

(Дэлгэрэнгүй мэдээллийг: www.greenclimate.fund)

Монгол Улс Үндэсний Хүлэмжийн Хийн Ялгарал, Шингээлтийн тооцоог 1990-2014 оноор гаргав.

2017 оны 8 дугаар сард Монгол Улс Үндэсний Хүлэмжийн Хийн Тооллогын тооцооллыг багтаасан анхны 2 жил тутмын үндэсний тайланг НҮБУАӨСК-д өргөн барилаа. Олон төрлийн эх үүсвэрүүдээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн тооцоог Уур амьсгалын асуудлаарх Засгийн хоорондын Мэргэжилтний хороо (IPCC)-оос гаргасан 2006 оны аргачлалын дагуу гүйцэтгэв. Одоогоор хавсралт 1-ийн бус орнууд 2006 оны тус аргачлалыг заавал ашиглах үүрэг хараахан хүлээгээгүй байгаа ч шинэчилж, сайжирсан аргазуу,

тоон утгууд орсон нь давуу тал болсон тул энэ удаагийн тайланд мөрдлөг болгов.

Үндэсний хүлэмжийн хийн тооллогын тайланд ерөнхийдөө IPCC, 2006 аргачлалын 1-р түвшний аргыг хэрэглэсэн боловч түлшний шаталт, хатуу түлшнээс үссэн дэгдэмхий хаягдал болон, Газар Ашиглалт, Газар Ашиглалтын Өөрчлөлт болон Ой (ГАГАӨО) зэрэг ангилалд 2-р түвшний аргыг ашигласан. Мөн, 2014 оныг суурь онтой харьцуулахад салбар тус бүрийн ялгарал, шингээлт өссөн байна.

1990-2014 оны Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал/шингээлтийг салбар бүрээр үзүүлэв:

САЛБАР	Ялгарал (GgCO ₂ e)		1990 оноос хойш өөрчлөлт (GgCO ₂ e)	1990 оноос хойш өөрчлөлт (%)
	1990	2014		
Эрчим хүч	11,091.14	17,267.79	6,176.64	55.69
Аж үйлдвэр	.66	328.06	109.39	50.03
Хөдөө Аж Ахуй	10,585.30	16,726.98	6,141.68	58.02
Хог хаягдал	55.62	159.91	104.29	187.49
Нийт (ГАГАӨО-с бусад)	21,950.73	34,482.73	12,532.00	57.09
ГАГАӨО	-23,024.18	-24,451.93	-1,427.75	6.20
Нийт (ГАГАӨО-г багтаасан)	-1,073.46	10,030.80	11,104.26	1,034.44

ГАГАӨО-Газар Ашиглалт, Газар Ашиглалтын Өөрчлөлт ба Ой

Анхны 2 жил тутмын үндэсний тайлангийн "Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тэдгээрийн үр дүн" бүлэгт Монгол Улс "Үндэсний хэмжээний Зорилтот Хувь нэмэр (INDC)"-д багтсан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах бодлого, арга хэмжээг товч тодорхойлсон. Мөн Цэвэр Хөгжлийн Механизм (ЦХМ), Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ) зэрэг олон улсын нүүрстөрөгчийн зах зээлийн механизмын үйл ажиллагаануудын мэдээллийг дурьдсан байна.

Салбар	Хэрэгжүүлэх арга хэмжээ
Эрчим хүч	Нийт эрчим хүчиний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчиний эзлэх хувь 7.62% (2014) байсан бол 2030 он гэхэд 30%-аар нэмэгдүүлэх.
	2030 он хүртэл 2014 онд дамжуулах түгээх үеийн алдагдал 13.7% байсныг 7.8% болгож бууруулах, эрчим хүчиний үрэлгэн хэрэглээ 14.4%-ыг 9.1% болгож багасгах.
	Барилгын дулааны алдагдалыг бууруулан, эрчим хүчиний үр ашгийг 2014 онтой харьцуулахад 2030 онд 40%-аар нэмэгдүүлэх
	2021 онд тээврийн хэрэгсэл, хөдөлгүүрийн түлшний хэрэглээг багасгах, авто замын сүлжээг сайжруулан, 11,000 км хатуу хучлагатай зам тавих, мөн төмөр замын голзамуудыг цахилгаанжуулах.
Аж үйлдвэр	2030 он хүртэл хий болон бага тулш зарцуулдаг нийтийн тээврийн хэрэгслийг 13%-аар өсгэх.
	2030 он гэхэд цементийн үйлдвэрлэл хуурай технологийг бүрэн нэвтрүүлэх.
	2025 он гэхэд дэвшилтэй техник, технологи нэвтрүүлж бүтээмжийг 25%-аар өсгэх.
Мал Аж Ахуй	2030 он гэхэд шатахууны хэрэгцээг дотоодод үйлдвэрлэсэн, Евро 5 стандартыг хангасан бүтээгдэхүүнээр 100% хангах.
	Малын тоо толгойг бууруулах.
	Малын ашиг шимийг дээшлүүлэх, түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэх.
Хөдөө Аж Ахуй	2021 онд 2008 онтой харьцуулахад сүргийн бүтцэд эзлэх хувийг тэмээ 0.3%, адuu 3.1%, үхэр 8%, хонь 2.7%-аар тус, тус өсгэх ямааг 14.1%-аар бууруулах зэрэг малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохиц харьцааг баримтлах.
	Хөрсийг салхи, усны элэгдэл эвдрэлээс хамгаалах зорилгоор хаалт бий болгох эрхзүйн орчинг бүрдүүлэх замаар тариалангийн газарт ойн зурvas байгуулах.
	2025 онд 20.0 ц/га хүртэл ургац авах, ургацын хэмжээг нэмэгдүүлэх.
Ой	Цомхогсон болон тэг элдэншүүлгийн технологийн тариалалтыг дэмжих, нэмэгдүүлэх замаар тариалангийн уламжлалт технологоос бүрэн татгалзах.
	2030 онд 1,500.0 мянган га-аар байгалийн аясаар сэргэн ургаж байгаа болон ойжуулсан талбайг нэмэгдүүлэх.
	2030 он хүртэл түймэрт шатсан болон хөнөөлт шавьжинд нэрвэгдсэн ойн талбайг 70%, 100%-аар бууруулах.
Хог хаягдал	Нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулах, хаягдалгүй технологийг нэвтрүүлэх.
	2022 онд 2013 онтой харьцуулахад хог хаягдлын эргүүлэн ашиглалтыг 7.6 дахин нэмэгдүүлэх
	2030 онд хог хаягдлын 40%-ийг дахин боловсруулдаг болох.

2018 онд Монгол улс удаах "Дэлхийн Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Үндэстний хэмжээнд Тодорхойлсон Хувь нэмэр (NDC)"-ийн бичиг, баримтыг өргөн барихаар төлөвлөж байна.

2015 онд "Дэлхийн Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Үндэстний хэмжээнд Зорилтот Хувь нэмэр (INDC)"-ийн бичиг, баримтадаа Монгол улс өргөн барсан ба УИХ-аас 2017 онд Парисын хэлэлцээрийг соёхон баталсны дараа анхны "Дэлхийн Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Үндэстний хэмжээнд Тодорхойлсон Хувь нэмэр (NDC)" болж өөрчлөгдсэн. NDC бичиг баримтанд тодорхойлогдсон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах бодлого, арга хэмжээнүүд нь цаашид ямар нэгэн арга хэмжээ аваагүй үед хүрэх хувилбар буюу BaU сценарийт харьцуулахад 2030 газард ГАГАӨО салбарыг оруулахгүй тооцоход Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарлыг 14 хувиар бууруулна хэмээн хүлээгдэж байна. Тус баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох арга хэмжээний ач холбогдлыг цохон тэмдэглэнээс гадна Монгол улсын уур амьсгалын өөрчлөлтөнд эмзэг, өртөмгийн нөхцөл байдлыг онцолж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицох арга хэмжээнд мал аж ахуй, бэлчээр, газар тариалан, усны нөөц, ойн салбарыг хамрагдаж байна.

Парисын хэлэлцээрээр бүх Талуудыг NDC-рээ дамжуулан хүчин чармайлтаа дээд зэргээр гаргахыг болон ирж буй жилүүдэд улам бэхжүүлэхийг шаардаж байна. Мөн бүх Талууд нь өөрсдийн орны хүлэмжийн хийн ялгарал болон авч хэрэгжүүлж буй хүчин чармайлтынхаа талаар тогтолц тайлагнах үүрэгтэй болжээ. Монгол Улс 2018 онд анхны NDC-гээ шинчлэхээр төлөвлөж байна. Мөн онд Талууд хамгийн дээд цэгт хүрээд буй дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын талаар богино хугацааны зорилт болон энэ зууны сүүлийн хагаст ялгаралтыг тэглэх урт хугацааны зорилтод NDC-үүд нь хэрхэн нийцэж буйг үнэлэхийн тулд дэмжлэг үзүүлэх хэлэлцүүлэг зохион байгуулна.

Энэхүү хэлэлцүүлэг нь Талуудыг Парисын хэлэлцээрийн зорилгод чиглэсэн хамтын хүчин чармайлтын үр дүнгийн боловсруулалтыг эхлүүлэхэд болон Талуудын цаашдын арга хэмжээ тус бүрийг мэдээлэхэд бэлтгэнэ. "Дэлхий нийтийн үр дүн" хэмээх энэхүү арга хэмжээг 5 жил тутам авч хэрэгжүүлнэ.

(Дэлгэрэнгүй мэдээллийг: <http://www4.unfccc.int/ndcregistry/Pages/Home.aspx>)